

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/193/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jennisbekh@audit.gov.mn
Аудитор: Б.Үүрийнтуяа
Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgiin@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.РОЗА ТАНАА

2024.02.28 № 100
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Сургуулийн нярвын ажлыг 2024 оны 4 дүгээр сард хүлээлцэх үед дутагдсан 2.4 сая төгрөгийн хүнсний материалыг баримтжуулаагүй, хүнсний материалын 4, 5 сарын үлдэгдэл 6.6 сая төгрөгөөр зөрүүтэй, санхүүгийн тайланг илүү дүнгээр тайлагнасан. Хүнсний материалын тайланд нягтлан бодогч, нярав нар гарын үсэг зурж баталгаажуулдаггүй, аудитаар үлдэгдлийг тооцоолох боломжгүй байна.

2. Хүнсний материалын үлдэгдлийг бодитоор тоолж баталгаажуулаагүй, тооллогын дүнгээр үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын 368.4 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан.

832502000914

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсгийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2 дах хэсгийн 20.2.3, 20.2.6 дах заалтууд болон УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, толилуулга, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд 6,658.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 6,252.0 сая төгрөг зарцуулж, 93.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Сургуулийн өмч хөрөнгийн бүртгэл тооллого, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>393,449,987.71</u>	<u>683,229,596.34</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	193,923,105.56	408,289,262.14
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	193,923,105.56	408,289,262.14
31110	Төгрөг	193,923,105.56	408,289,262.14
31140	Касс арилжааны банк	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	2,323,213.10	6,052,925.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,323,213.10	6,052,925.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	9,077,000.00	522,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	9,077,000.00	522,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	188,126,669.05	268,365,409.20
354	Хангамжийн материал	188,126,669.05	268,365,409.20
35410	Бичиг хэргийн материал	7,624,300.00	9,808,940.00
35420	Аж ахуйн материал	3,538,000.00	49,919,200.00
35440	Түлш, шатах тослох материал	360,000.00	360,000.00
35460	Хүнсний материал	54,785,606.05	49,384,820.46
35470	Бусад хангамжийн материал	121,818,763.00	158,892,448.74
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,244,918,494.49</u>	<u>5,130,564,361.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,244,918,494.49	5,130,564,361.12
392	Биет хөрөнгө	4,183,101,088.88	5,068,856,955.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,296,533,384.00	4,958,920,368.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(591,287,386.00)	(659,435,798.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	396,153,929.07	592,662,340.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(192,923,106.12)	(102,886,529.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	264,825,291.00	266,773,979.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(139,414,734.64)	(128,175,663.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	148,491,890.00	129,100,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(67,504,847.81)	(57,978,508.35)
39217	Ном	68,226,669.38	69,876,669.38
393	Биет бус хөрөнгө	61,817,405.61	61,707,405.57
39301	Программ хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(155,833.39)	(265,833.43)

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39303	Бусад биет бус хөрөнгө	60,000,000.00	60,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,638,368,482.20</u>	<u>5,813,793,957.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>229,016,663.32</u>	<u>284,887,765.45</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	229,016,663.32	284,887,765.45
413	Өглөг	229,016,663.32	284,887,765.45
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	152,671,234.13
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	<u>229,016,663.32</u>	<u>132,216,531.32</u>
41361	Байгууллагад төлөх өглөг	229,016,663.32	132,216,531.32
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,409,351,818.88</u>	<u>5,528,906,192.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,409,351,818.88	5,528,906,192.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	957,261,982.90	957,261,982.90
51101	Өмч: - төрийн	957,261,982.90	957,261,982.90
512	Хуримтлагдсан үр дүн	640,930,191.87	1,775,879,774.00
51210	Өмнөх үеийн үр дүн	267,864,709.95	656,325,400.87
51220	Тайлант үеийн үр дүн	373,065,481.92	1,119,554,373.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,811,159,644.11	2,795,764,435.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,638,368,482.20</u>	<u>5,813,793,957.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>4,917,756,573.88</u>	<u>7,483,508,156.74</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>239,904,073.88</u>	<u>1,022,532,556.74</u>
120	Нийтлэг татварын бус орлого	239,904,073.88	1,022,532,556.74
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,500,000.00	5,790,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	5,790,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	233,043,073.88	939,832,144.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	5,361,000.00	76,910,412.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>4,677,852,500.00</u>	<u>6,460,975,600.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,425,997,500.00	5,978,981,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,425,997,500.00	5,978,981,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	251,855,000.00	481,994,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	251,855,000.00	477,594,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	4,400,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>4,544,691,091.96</u>	<u>6,363,953,783.61</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>4,544,691,091.96</u>	<u>6,363,953,783.61</u>

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,405,278,091.96	6,194,149,385.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,276,207,018.73	4,754,877,619.01
210101	Үндсэн цалин	2,175,746,821.64	2,797,412,307.07
210102	Нэмэгдэл	897,187,370.19	1,659,545,910.94
210104	Урамшуулал	203,272,826.90	297,919,401.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	412,109,805.38	594,231,300.61
210201	Тэтгэврийн даатгал	278,561,105.38	409,336,600.61
210202	Тэтгэмжийн даатгал	33,387,100.00	46,223,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,709,800.00	23,111,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,677,400.00	23,111,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	66,774,400.00	92,447,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	319,248,246.32	379,668,868.00
210301	Гэрэл, цахилгаан	15,574,775.00	26,145,100.00
210302	Түлш, халаалт	303,673,471.32	353,523,768.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,429,600.00	60,405,437.00
210401	Бичиг хэрэг	9,734,300.00	25,245,160.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,695,300.00	18,165,601.00
210408	Бараа материал акталсны зардал	-	16,994,676.00
2105	Нормативт зардал	201,779,723.22	163,996,528.09
210502	Хоол, хүнс	201,779,723.22	163,996,528.09
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,112,700.00	8,168,300.00
210604	Урсгал засвар	10,112,700.00	8,168,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,998,000.00	47,141,134.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,790,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,998,000.00	41,351,134.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,392,998.31	185,660,198.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,559,160.00	32,779,686.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,151,560.00	3,026,034.90
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,682,278.31	149,854,477.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,413,000.00	169,804,397.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	139,413,000.00	169,429,397.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	139,413,000.00	136,585,998.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	32,843,399.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	375,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	375,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>373,065,481.92</u>	<u>1,119,554,373.13</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
145003	Хөрөнгө оруулалтын олз	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	-	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>373,065,481.92</u>	<u>1,119,554,373.13</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,679,352,500.00</u>	<u>6,466,765,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,500,000.00	5,790,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,500,000.00	5,790,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,500,000.00	5,790,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.00	5,790,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,677,852,500.00	6,460,975,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,425,997,500.00	5,978,981,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,425,997,500.00	5,978,981,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	251,855,000.00	481,994,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	251,855,000.00	477,594,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		4,400,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>4,452,690,252.24</u>	<u>6,165,286,243.42</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,452,690,252.24	6,165,286,243.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,313,277,252.24	5,984,537,933.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,286,180,604.24	4,622,371,197.39
210101	Үндсэн цалин	2,187,143,307.15	2,664,905,885.06
210102	Нэмэгдэл	897,187,430.19	1,659,545,910.94
210104	Урамшуулал	201,849,866.90	297,919,401.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	417,340,200.00	577,796,200.00
210201	Тэтгэврийн даатгал	283,791,500.00	392,901,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	33,387,100.00	46,223,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,709,800.00	23,111,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,677,400.00	23,111,800.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	66,774,400.00	92,447,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,755,000.00	476,094,000.00
210301	Гэрэл, цахилгаан	15,574,775.00	26,145,100.00
210302	Түлш, халаалт	235,180,225.00	449,948,900.00
2105	Нормативт зардал	260,933,328.00	147,651,730.50
210502	Хоол, хүнс	260,933,328.00	147,651,730.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,125,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,125,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоод албан томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,634,320.00	47,141,134.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,790,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,634,320.00	41,351,134.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,333,800.00	112,358,670.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,465,440.00	82,292,835.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,868,360.00	30,065,835.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,413,000.00	180,748,309.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	139,413,000.00	180,373,309.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	139,413,000.00	147,529,910.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		32,843,399.90
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	375,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		375,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>226,662,247.76</u>	<u>301,479,356.58</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	97,016,600.00	87,113,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	97,016,600.00	87,113,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	97,016,600.00	87,113,200.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	97,016,600.00	87,113,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(97,016,600.00)</u>	<u>(87,113,200.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	129,645,647.76	214,366,156.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	64,277,457.80	193,923,105.56

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	193,923,105.56	408,289,262.14
----	--	----------------	----------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	640,930,191.87	4,409,351,818.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	640,930,191.87	4,409,351,818.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	640,930,191.87	4,409,351,818.88
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	640,930,191.87	4,409,351,818.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			15,395,209.00	15,395,209.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	957,261,982.90	2,811,159,644.11	656,325,400.87	4,424,747,027.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(15,395,209.00)		(15,395,209.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			1,119,554,373.13	1,119,554,373.13
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	957,261,982.90	2,795,764,435.11	1,775,879,774.00	5,528,906,192.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,658,261,200.00	6,252,024,443.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,658,261,200.00	6,252,024,443.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,469,694,900.00	6,071,651,133.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,703,486,300.00	4,622,371,197.39
210101	Үндсэн цалин	2,890,223,300.00	2,664,905,885.06
210102	Нэмэгдэл	1,567,187,300.00	1,659,545,910.94
210104	Урамшуулал	246,075,700.00	297,919,401.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	587,935,600.00	577,796,200.00
210201	Тэтгэврийн даатгал	399,796,300.00	392,901,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	47,034,900.00	46,223,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,517,400.00	23,111,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	23,517,400.00	23,111,800.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	94,069,600.00	92,447,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	476,094,000.00	476,094,000.00
210301	Гэрэл, цахилгаан	12,473,000.00	26,145,100.00
210302	Түлш, халаалт	463,621,000.00	449,948,900.00
2105	Нормативт зардал	395,644,700.00	147,651,730.50
210502	Хоол, хүнс	395,644,700.00	147,651,730.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,125,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,125,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	75,764,800.00	49,391,134.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,922,100.00	5,790,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	69,842,700.00	43,601,134.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	229,269,500.00	197,221,870.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	197,631,100.00	166,116,035.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,638,400.00	31,105,835.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,566,300.00	180,373,309.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,566,300.00	180,373,309.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	155,722,900.00	147,529,910.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,843,400.00	32,843,399.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,658,261,200.00	6,466,390,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,978,981,600.00	5,978,981,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,978,981,600.00	5,978,981,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	481,994,000.00	481,619,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	477,594,000.00	477,219,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	4,400,000.00	4,400,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	197,285,600.00	5,790,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,422,100.00	5,790,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	192,863,500.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		193,923,105.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		408,289,262.14
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	197	197
620001	Удирдах ажилтан	1	1

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	135	135
620003	Үйлчлэх ажилтан	61	61
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	197	197
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	136	136
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	61	61

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм..

Тайлант оны зорилго: “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж , боловсролын үйлчилгээний хүртээмж , чанарт ахиц гаргах”

Энэ зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

- I. Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилтанд сурталчлан таниулах , тэдний оролцоотой хэрэгжүүлэх
- II. Алслагдсан багт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт , үйл ажиллагаагаар дэмжих
- III. Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх,арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх,сурлагын амжилтад ахиц гаргах
- IV. Багшийн хөгжлийг дэмжих , ажлын байранд хөгжих нөхцөл бололцоогоор ханган , бусад сургуулиудын сайн туршлагаудыг судлах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,175.4 сая төгрөгөөр буюу 25.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	193,923.11	408,289.26	214,366.16
Авлага	2,323.21	6,052.93	3,729.71
Урьдчилж гарсан зардал	9,077.00	522.00	(8,555.00)
Бараа материал	188,126.67	268,365.41	80,238.74
Нөөцийн бараа			-
Үндсэн хөрөнгө	4,244,918.49	5,130,564.36	885,645.87
Нийт хөрөнгө	4,638,368.48	5,813,793.96	1,175,425.48

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өр төлбөр	229,016.66	284,887.77	55,871.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,409,351.82	5,528,906.19	1,119,554.37
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,638,368.48	5,813,793.96	1,175,425.48

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал дансуудад бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 408.3 сая төгрөг болж оны эхнээс 214.4 сая төгрөгөөр өссөн нь байна. Үүний 91.2 сая төгрөг нь цалин хөлс, 246.8 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардал, 8.9 сая төгрөг нь үдийн цайны зардал, 61.4 сая төгрөг нь бусад зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Авлага дансны оны эхний 2.3 сая төгрөгийн үлдэгдэлийг барагдуулж, оны эцэст 6.1 сая төгрөгийн авлагатай гарсан нь ээлжийн амралтын зөрүүтэй холбоотой авлага байгаа боловч авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Урьдчилж гарсан зардал дансны оны эхний 8.6 сая төгрөгийн үлдэгдлийг үндсэн хөрөнгө хүлээн авч барагдуулсан байна.

Бараа материалын данс 80.2 сая төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлээс бичиг хэрэг, аж ахуйн материал, бусад хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Үүнд: аж ахуйн материалын үлдэгдэл 43.2 сая, бичиг хэрэг 2.2 сая, бусад хангамжийн материал 37.7 сая төгрөгөөр өссөн. БШУЯ-наас 76.1 сая төгрөгийн үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,130.5 сая төгрөг болж 885.6 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 95.7 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 939.8 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 192.4 сая төгрөгийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тогтоолоор акталж устган, үндсэн хөрөнгөнд 149.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өглөг дансны оны эхний түлш халаалтын өглөгөөс 96.8 сая төгрөгийн барагдуулж нэмж өглөг үүсээгүй, оны эцэст шинээр 152.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн татварын өглөгтэй гарсан нь 12 дугаар сарын 29-нд орж ирсэн санхүүжилтийг зарцуулж чадаагүй оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Тайлант онд 1,119.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 1,119.6 сая төгрөгөөр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 6,814.6 сая сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Сургуулийн 2024 оны төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,979.0 сая төгрөгөөр, оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэх дүнг 192.9 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5.9 сая төгрөгөөр баталсан байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 477.6 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт оруулаагүй байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,979.0 сая, орон нутгийн төсвөөс 477.2 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 5.8 сая, орон төсвийн төсвөөс 4.4 нийтдээ 6,466.4 сая төгрөгийн санхүүжилт авч, 192.9 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,252.0 сая төгрөг буюу 93.9 хувьтай дансанд 408.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь оны эцэст санхүүжилт хуваарилагдаж зарцуулж чадаагүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Ерөнхий боловсрол-71802						
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	7,579.30	7,579.30	-	100.0
2	80233	Хүүхэд хамгаалал	7,270.00	6,110.00	1,160.00	84.0
3	80312	Сургалт семинар	5,052.90	4,138.00	914.90	81.9
4	81605	Эрүүл мэндийг дэмжих	8,328.50	2,391.50	5,937.00	28.7
5	81801	үдийн цай хөтөлбөр	155,722.90	147,529.90	8,193.00	94.7
6	81806	Дотуур байрны үйлчилгээ	1,566,174.30	1,318,771.30	247,403.00	84.2
7	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	64,229.40	63,179.20	1,050.20	98.4
8	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	25,863.40	5,691.90	20,171.50	22.0
9	81827	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	69,609.30	69,208.00	401.30	99.4
10	81834	Боловсролын стандарт, сургалтын зардал	3,925,578.30	3,812,047.90	113,530.40	97.1
11	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	318,859.40	318,859.40	-	100.0
12	81848	Сурах бичгийн түрээс	5,922.10	5,790.00	132.10	97.8
13	81875	Мэдээлэл технологийн үйлчилгээ	16,077.40	9,109.00	6,968.40	56.7
14	83602	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	4,400.00	4,400.00	-	100.0
15	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	477,594.00	477,219.00	375.00	99.9
Нийт дүн			6,658,261.20	6,252,024.40	406,236.80	93.9

Эх сурвалж: Аудитын хийсэн ТГТайлан

Сургуулийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 406.2 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалин, НДШ-ийн зардал 91.2 сая, норматив зардал 248.0 сая, үдийн цай 8.2 сая, бараа үйлчилгээний бусад зардал 58.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй байгаатай холбоотой байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ахмадын сан байгуулаагүй, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргаагүй байна. Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 49.3 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 197.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус байгууллагад 2024 онд 197 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 135, үйлчлэх ажилтан 61 нийтдээ 197 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 379.4 сая төгрөгийн бараа материал, 87.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 01/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,544.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 45.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,363.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 63.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын FAS программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 449.0 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалттай холбоотой 55.4 сая төгрөгийн 4 гүйлгээний мэдээллийг таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт мэдээлээгүй, оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, мэдээлээгүй.

Шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 2.3 сая төгрөгийн 3 шийдвэрийг байршуулаагүй, оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, мэдээлээгүй, өмнөх оны аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан оруулаагүй шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 93.7 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 559.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 559.7 сая төгрөгийн 3 албан шаардлага өгөгдсөн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд 24 албан шаардлагын зөрчлийг бүрэн арилгаж, 1 албан шаардлага буюу 547.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллоготой холбоотой зөрчлийн давтан гаргасан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	559,734.0	2	12,385.1	2.2%
Зөвлөмж					
Нийт дүн	3	559,734.0	2	12,385.1	2.2%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлалттай байдалтай холбоотой санхүүгийн тайлагнал, санхүүгийн баримтыг түүврийн аргаар эрсдэлд тооцож үзсэн тул цалин хөлсний олголт, НДШ-ийн ногдуулалтын тооцоолол, бусад зардал, авлага, өглөг, бараа материалын зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,659.6 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд 6,659.6 сая төгрөгийн алдааг залрууллаа. Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн үлдэгдлийг 0.1 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.
- Тайлант онд НДШ-ийн 137.4 сая төгрөгийн өглөгтэй гарсныг 1.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулах бичилтүүдийг хийгээгүй алдаатай ирүүлсэн тул 6,658.3 сая төгрөгийн тайланг бүхэлд нь залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалаар баталсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах журам”, 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 281.1 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 281.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.Үүнд:

1. Сургуульд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон 4 ажилтнаас 11.5 хувиар бодож 1,058,973.98 төгрөгийн шимтгэлийг илүү суутгаж, ажил олгогчоос төлөх шимтгэлээс 1,344,919.96 төгрөгийг буюу 12.5 хувиар ногдуулж нийгмийн даатгалын санд илүү төвлөрүүлсэн.

Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллаж буй 7 багшид сар бүр үндсэн цалингийн 10 хувь олгох ёстойгоос 4 сар 20 хувиар 3,653,090 төгрөгийн нэмэгдэл, 1 багшид ээлжийн амралтын 6, 8 дугаар саруудад ажиллаагүй үед 249,100 төгрөгийн нийтдээ 3,902,190 төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон.

Санхүүгийн тайланд тусгасан 6,052,925 төгрөгийн ажиллагсдаас авах авлага нь 6 дугаар сард олгосон ээлжийн амралтын тооцоогоор жирэмсэн амаржсаны амралттай ажилтанд ээлжийн амралтыг зөрүүтэй тооцоолсонтой холбоотой гэх боловч цалингийн цэсээр түүвэрлэж шалгахад 6,352,925 төгрөг буюу 300,000 төгрөгөөр зөрүүтэй байна.Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж ажилтан тус бүрээр тооцоолох боломжгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4-д "ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч", 18 дугаар зүйлийн 18.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө", 21 дүгээр зүйлийн 21.1...,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 26 дугаар зүйлийн 26.1-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.6-д "бүх зардал" гэсэн заалтууд, Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Тусгай сургалтын байгууллагын зардал тооцох, зарим албан тушаалтанд нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2.8-д "Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгоно. (Засгийн газрын 2020 оны 208 дугаар тогтоолоор нэмсэн бөгөөд үүнийг 2021.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө", Сангийн

сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөө.

2. Авлигатай тэмцэх газрын 2024.04.05-ны өдрийн 05/6137 тоот зөвлөмжийн дагуу тус сургуулийн нярвыг 2024 оны 4 дүгээр сард ажлаас нь чөлөөлж, ажил хүлээлцэх үед 2,353,329.21 төгрөгийн хүнсний материал дутагдаж, дутуу хүлээлгэн өгсөн нь баримтаар нотлогдсон гэх боловч баримтжуулаагүй, 4 дүгээр сарын эцсийн үлдэгдэл, 5 сарын эхний үлдэгдэл 6,590,593.05 төгрөгөөр зөрүүтэй.

Сургуулийн нярвын ажил жилийн турш 3 хүнээр дамжсан, дотуур байрны хоол хүнсний үлдэгдэл зөрүүтэй. Санхүүгийн тайлангаарх хүнсний оны эцсийн үлдэгдэл 38,413,820.46 төгрөг, нярвын тайлангаарх үлдэгдэл 32,966,629.05 төгрөг буюу 5,447,191.46 төгрөгөөр, худалдан авсан болон зарцуулалтын дүнгүүд нь хоорондоо зөрүүтэй. Жилийн эцсийн хүнсний тооллогыг программын үлдэгдлээр тоолсон, бодит үлдэгдлийг баталгаажуулаагүй, материалын тайланд нягтлан бодогч, нярав нар гарын үсэг зурж баталгаажуулдаггүй, аудитаар үлдэгдлийг тооцоолох боломжгүй байна.

Сургуулийн захирлын 2024 оны Б/69 дүгээр тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хөтөлсөн боловч тооллогын дүнг хэлэлцэж илтгэх хуудас бичээгүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо бодсон акт үйлдэж, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, үүнээс шалтгаалан санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө болон зарим бараа материалын 38,413,820.46 төгрөгийн хүнсний үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй, өмнөх оны зөрчлийг давтан гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1 дэх хэсэг, “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3 дугаар хэсгийн 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-т “журналд бичих”, 14.3.3-д “дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана. 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2025

оны А/3 дугаар тушаалаар баталсан батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар 506.7 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны веб сайтын мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 449.0 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалттай холбоотой 55.4 сая төгрөгийн 4 гүйлгээний мэдээллийг таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт мэдээлээгүй.

Шилэн дансанд байршуулах төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 2.3 сая төгрөгийн 3 шийдвэрийг байршуулаагүй, оны эхэнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж, мэдээлээгүй, өмнөх оны аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг оруулаагүй шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 93.7 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.1, 6.4, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор” 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” , 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” заасны дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж ажиллах, өмч, хөрөнгө зарцуулсан тушаалыг шилэн дансанд нөхөж байршуулах.

2. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол, үдийн хоол 295.1 сая төгрөг, худалдан авсан үндсэн хөрөнгө 51.6 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмж болон бусад шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг зөрүүтэй, тайлант оны НДШ-ийн өглөгийг илүү тайлагнасан.	1	1,354.1			1	1,354.1	1	1,354.1				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн алдаатай тайлагнасан.	1	6,658,261.2			1	6,658,261.2	1	6,658,261.2				
Дүн	3	6,659,615.3	1		1	6,659,615.3	1	6,659,615.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1. ХЧАТ тогтоолгосон 4 ажилтны НДШ-ийг илүү төвлөрүүлсэн. Тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажилладаг багшийн нэмэгдэл илүү олгосон.	1	12,659.1			1	12,659.1						

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Ажиллагсдаас авах авлагыг зөрүүтэй тайлагнасан.												
Хүнсний үлдэгдлийг баримтжуулаагүй, бараа материалын тайлан зөрүүтэй, тооллогын дүнг баталгаажуулаагүй.	1	268,365.4			1	268,365.4						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй.	1	0					1	-				
Нягтлан бодогч нь өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн.	1								1	-		
Дүн	4	281,024.5			2	281,024.5	1	-	1	-		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Санхүүжилтийн орлого дутуу мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	506,726.4						1	506,726.4
Дүн	1	506,726.4						1	506,726.4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1	506,726.4						1	506,726.4